МЭДЭЭ · 2024 оны 4-р сарын 10

ДӨРВӨН ХҮҮХДИЙГ ТӨРСНИЙ ГЭРЧИЛГЭЭТЭЙ БОЛГОЖ, ХҮҮХДИЙН МӨНГИЙГ НӨХӨН ОЛГУУЛАХААР БОЛЛОО



Нийслэлийн прокурорын газраас төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд бичиг баримтгүйн улмаас сурч боловсрох, эмнэлгийн үйлчилгээ авах зэрэг эрх нь зөрчигдөж байсан хүүхдүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авчээ.

Энэ хүрээнд эцэг, эх, асран хамгаалагчгүй 4 хүүхдийг бичиг баримттай болгох зорилгоор Иргэний бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасны дагуу шүүхээр насыг нь тогтоолгож, иргэний бүртгэлд бүртгүүлэн төрсний гэрчилгээтэй болгосон байна.

Үүний үр дүнд тухайн хүүхдүүд сурч боловсрох, эмнэлгийн үйлчилгээ авах, төрөөс олгож буй хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах боломжтой болсон байна. Мөн прокуророос тэдгээр хүүхдүүдийн өмнө нь аваагүй мөнгөн тэтгэмжийг нөхөн олгуулахаар Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлжээ.

Түүнчлэн “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-д дээрх байдлаар эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр нэмэлт

өөрчлөлт оруулах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

6 дугаар зүйл. Төрсний бүртгэл

6.6. Эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй хүүхдийг асрамжлан авах хүсэлтэй иргэн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын төлөөлөгч тухайн хүүхэд олдсон өдрөөс хойш 2 хоногийн дотор цагдаагийн байгууллагад тэмдэглүүлнэ.

6.7. Энэ хуулийн 6.6-д заасан тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлж хүүхдийг төрсний бүртгэлд бүртгүүлнэ:

6.7.1. Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

6.7.2. Хүүхдийн нас тогтоосон тухай шүүхийн шийдвэр, эсхүл шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчийн дүгнэлт.

ХҮҮХДИЙН ЭРХ

ОВОГ НЭР, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛТАЙ БАЙХ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

СУРЧ БОЛОВСОРЧ, ХӨГЖИХ

prosecutor.mn facebook.com/prosecutor.mn twitter.com/prosecutor_mn

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1126